Төсөл

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны ...дугаар
сарын...-ны өдөр Дугаар ..... Улаанбаатар хот

Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 224 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам”-д доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт, дэд заалт тус тус нэмсүгэй:

1/ 1 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт:

“1.6.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу зарцуулалт хийхтэй холбоотой шийдвэрийг Засгийн газар гаргана.”

2/ 1 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт:

1.7.Иргэн бүр хуримтлалын нэрийн данснаас зарцуулалт хийх банкны данс /цаашид “зарцуулалтын данс” гэх/-тай байна.

3/ 1 дүгээр зүйлийн 1.8 дахь заалт:

1.8.Иргэн зарцуулалтын данс байрших банкыг өөрчлөх боломжтой бөгөөд тухайн банк иргэний хуримтлалын сангийн зарцуулалтын дансны мэдээллийг төв байгууллагад тухай бүр ирүүлнэ.

4/ 1 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт:

1.9.”орон сууцны дэмжлэг үзүүлэх” гэж орон сууц худалдан авах болон орон сууц ашиглалттай холбоотой ус, дулаан, цахилгаан хангамжийн үйлчилгээ, түлш худалдан авах зориулалтын төлбөрийг ойлгоно.

5/ 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх дэд заалт:

“5.1.4.эрүүл мэндийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмийн үнийн зардал, ахмадын сувиллын төлбөр төлөх зориулалтаар;”

6/ 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь дэд заалт:

"5.1.5.орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор түүний ашиглалтын зардал болох орон сууцны ус, дулаан, цахилгаан хангамжийн үйлчилгээний төлбөр төлөх, сайжруулсан түлш худалдан авах зориулалтаар;

7/ 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалт:

“5.7.Төв байгууллага нь хуримтлалын сангаас зарцуулалт хийхтэй холбогдуулан иргэн бүрийн зарцуулалтын дансны мэдээллийг банкнаас хүлээн авч, мэдээллийн санд оруулна.”

8/ 5 дугаар зүйлийн 5.8 дахь заалт:

“5.8.Төв байгууллага нь Монголбанкан дахь хуримтлалын сангийн данснаас банкан дахь иргэн бүрийн зарцуулалтын данс руу төрийн сангийн системээр дамжуулан гүйлгээ хийх, эсхүл тухайн банкны данс руу нийт дүнгээр гүйлгээ хийж болно.”

9/ 5 дугаар зүйлийн 5.9 дэх заалт:

“5.9.Банк Ахмад настны тухай хуулийн 3.1-д заасан ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан 18 нас ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд энэ журмын 5.1.4, 5.1.5-д заасан зориулалтаар ашиглах зарцуулалтын дансны төлбөрийн картыг олгоно.”

10/ 5 дугаар зүйлийн 5.10 дахь заалт:

"5.10.0-18 хүртэлх насны хүүхдийн банк дахь зарцуулалтын данс нь хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтран эзэмших данс байна.”

11/ 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэг:

“5.11.Иргэн зарцуулалтын дансны мөнгөн хөрөнгийг энэ журмын 5.1.4, 5.1.5-д заасан зориулалтаар төлбөрийн карт, эсхүл цахим банкны үйлчилгээ, цахим төлбөрийн баримтын системийг тус тус ашиглан дараах журмаар зарцуулна:”

“5.11.1.энэ журмын 5.1.4-д заасан зориулалтаар бол эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, ахмадын сувилалын байгууллагын холбогдох дансанд шилжүүлнэ.”

“5.11.2.энэ журмын 5.1.5-д заасан зориулалтаар бол орон сууцны ус, дулаан, цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, сайжруулсан түлш худалдан борлуулагч байгууллагын дансанд шилжүүлнэ.”

“5.11.3.энэ журмын 5.1.4, 5.1.5-д заасан зориулалтаар үйлчилгээ үзүүлэх байгууллага нь сүүлийн 1-ээс доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байна.”

“5.12.энэ журмын 5.1.5-д заасан ахмадын сувиллын байгууллага нь “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл авсан, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байна.”

12/ 8 дугаар зүйлийн 8.10-8.12 дахь заалт:

“8.10.Банк энэ журмын 5.1.4, 5.1.5-д заасан зориулалтын дагуу хийгдсэн зарцуулалтын гүйлгээний мэдээллийг Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн сан болон цахим төлбөрийн баримтын системд тухай бүр цахим хэлбэрээр дамжуулна.”

“8.11.Хуримтлалын сангийн мэдээллийн сан нь 5.1.4, 5.1.5-д заасан зориулалтын дагуу хийгдсэн банк болон цахим төлбөрийн баримтын системийн гүйлгээний мэдээллийг өөрийн бүртгэлтэй харилцан тулгаж, гүйлгээний бүрэн бүтэн байдал, зарцуулалтын дүн болон мэдээллийн зөрүүг хянана.”

“8.12.Хуримтлалын сангийн мэдээллийн сан нь 5.1.4, 5.1.5-д заасан зориулалтаар зарцуулалт хийсэн талаарх мэдээллийн тулгалтаар зөрүү илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагууд зөрүүгийн шалтгааныг тодруулж, мэдээллийг залруулах, нийцүүлэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.”

13/ 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт:

“9.3.Банк нь хуримтлалын сангийн зарцуулалтын данснаас хийгдэх төлбөрийн гүйлгээний баталгаажуулалт, гүйцэтгэл, аюулгүй байдлыг хариуцна.”

2.Мөн журмын дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр бүлгийн 1.4 дэх заалт:

“1.4.Иргэн хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг энэ журмын 5.1.3-т заасан зориулалтаар зарцуулах Гэр бүлийн тухай хуулийн 4.1.6.а, 4.1.6.б-д заасан гэр бүлийн гишүүнд нэг удаа шилжүүлж болно.”

2/ 4 дүгээр бүлгийн 4.1 дэх заалт:

“4.1.Төв байгууллага нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.4-т заасны дагуу Хуримтлалын сангийн дансанд тухайн жилд байршуулсан нийт мөнгөн хөрөнгийг журмын 2.2-т заасан мэдээлэлд үндэслэн тооцож, бүртгэл хөтөлнө.”

3/ 4 дүгээр бүлгийн 4.2 дахь заалт:

“4.2.Энэ журмын 4.1-д заасан бүртгэлд тухайн жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэлд бүртгэлтэй Монгол Улсын иргэн бүр хамаарна.”

4/ 4 дүгээр бүлгийн 4.3 дахь заалт:

“4.3.Төв байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан хүүг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансны эхний үлдэгдэл, хуваарилсан дүн, зарцуулалтыг тооцож, Хуримтлалын сангийн дансанд байршуулсан дүнгээр бүртгэл хөтөлнө.”

5/ 5 дугаар бүлгийн 5.1 дэх заалт:

“5.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2-т заасан дараах зориулалтаар дэмжлэг үзүүлнэ:”

6/ 6 дугаар бүлгийн 6.1 дэх заалт:

“6.1.Иргэн энэ журмын 1.4-т заасны дагуу хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгөө шилжүүлэх, 5.1.1-5.1.3-т заасан нөхцөлийг хангасан бол Хуримтлалын сангаас дэмжлэг авах хүсэлтээ цаасаар, эсхүл цахимаар төв байгууллагад гаргана.”

7/ 6 дугаар бүлгийн 6.2.2 дахь заалт:

“6.2.2.Гэр бүлийн тухай хуулийн 4.1.6.а, 4.1.6.б-д заасан гэр бүлийн гишүүнийг нотлох баримт бичиг.”

8/ 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалт:

“6.3.Иргэн энэ журмын 1.5-д заасны дагуу хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг өвлөх бол Нотариатын тухай хуулийн дагуу өвлөх эрхийн гэрчилгээ авна. Нотариатч өвлөх эрхийн гэрчилгээ олгосон мэдээллийг хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн санд дамжуулна. Төв байгууллага нь нотариатчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн иргэний өвлөх хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.”

3.Мөн журмын Зургаадугаар бүлгийн гарчгийн “өвлөх” гэснийг, 5.1.1-д заасан "эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх болон" гэснийг тус тус хассугай.

4.Мөн журмын 4.2.1-4.2.5 дахь дэд заалт, 4.5 дахь заалт, 4.6 дахь заалт, 6.3.1, 6.3.2 дахь дэд заалт, 6.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайд Т.Аубакирт даалгасугай.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлийн “5 дахь хэсгийг” гэснийг “5.1.1-5.1.3 дахь дэд заалтыг” гэж өөрчилсүгэй.

7.“Журам батлах тухай” Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 224 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам”-ын 5.1.4-5.1.5 дахь дэд заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ